

Хүний хөгжлийн ойлголт

С.Батбилэг

**ЭМНХЯ-ны Хүн ам, нийгмийн
хамгааллын газрын мэргэжилтэн**

1. Хүний хөгжил гэж юу вэ?

Тодорхойлолт

- Хүний тогтвортой хөгжил гэдэг нь "Хүн" төвтэй хөгжлийн үйл явцыг хэлдэг бөгөөд энэ эрнийхэн хойч үеийнхээ боломж, сонголтыг багасгахгүй байна.

Ерөнхий ойлголт

- Хүний хөгжил гэдэг нь хүмүүсийн аливаа зүйлийг сонгох үйл явцыг өргөжүүлэхийг хэлнэ. Гэвч энэ нь хойч үеийнхээ хүмүүсийн сонголт хийх боломжийг багасгана гэсэн үгт биш. Сонголт нь: эрүүл саруул байж, урт насалж удаан амьдрах, өндөр боловсрол эзэмших, хөрөнгө мөнгөтэй байх, бодлого, шийдвэр гаргахад оролцох, хүрээлэн байгаа орчноо ариг гамтай ашиглаж, хойч үедээ өвлүүлэх, улс төрийн эрх чөлөөтэй байх, баталгаатай хүний эрхтэй байх, бие биенээ хүндтэдгэх зэрэг болно.

Хөгжил гэдэг нь:

- эрүүл энх, эрдэм боловсрол, эд баялагтай байхыг,
- ядуурал, өвчин зовлон, ялгаварлан гадуурхах дарамт, дайн дажингүй, амьдралын амар баясгаланг эдлэхийг,
- хүмүүс хөгжлийн үйл явцад идэвхитэй оролцохыг хэлнэ.

Хүний хөгжли нь хоёр талтай: хүний бүх боломжийг бүрдүүлэх – эрүүл мэндээ сайжруулах, мэдлэг боловсролоо дээшлүүлэх, нөгөө талаас өөрийн олж авсан боломжоо ахуй амьдралдаа ашиглах, соёл урлаг, нийгмийн болон улс төрийн амьдралд оролцох. Хэрвээ энэ хоёр тал тэнцүү харьцаатай биш бол хүний хөгжил нь хямралд орж болзошгүй юм.

Хүний хөгжлийн энэ үзэл баримтлалын дагуу орлого бол хүмүүсийн ганц сонирхох зүйл мөн боловч тэдний амьдралын зорилго нь биш билээ. Хөгжил нь орлого болон амьдрах таатай нөхцөлийн цогц байх ёстой бөгөөд хүмүүс рүү чиглэгдсэн байна.

Хөгжил нь:

- зөвхөн эдийн засгийн өсөлтийг урамшуулахгүй, түүний үр ашгийг тэгш хувиарлахад,
- хүрээлэн байгаа орчноо ариг гамтай ашиглахад,
- хүмүүсийн бүх бололцоог нээн илрүүлэхэд оршино.


Хөгжил нь:

- ядуус, эмэгтэйчүүд,
- хүрээлэн байгаа орчин,
- ажил эрхлэлт зэрэг асуудлаар
- нийгмийн болон улс төрийн амьдралд оролцохыг хэлнэ.

2. Дэлхийн хүний хөгжлийн илтгэлүүдийн талаар

Хүний хөгжлийн илтгэл 1990

Эдийн засгийн өсөлт нь хүний хөгжлийн асуудалд хэрхэн нөлөөлж байгааг үзүүлэвэл:



Энэ графикт 130 орон хамрагдсан болно.

Дээрхи графикт улс орнуудын хүний хөгжлийн болон 1 хүнд ногдох үндэсний орлогын үзүүлэлтийг харуулав. Цагаан зураасаар улс орнуудыг хүний хөгжлийн индексээр нь байрлуулж, хар зураасаар ҮНБ-ээр байр эзлүүлсэн байна. эндээс улс орнуудын орлогын түвшингийн ялгаа нь хүний хөгжлийнхээс элт давуу байгааг харж болно. Тухайн орны 1 хүнд ногдох орлого, түүний хөгжлийн түвшинг хооронд нь шууд холбосон зүйл биш юм.

Энэ илтгэл нь хүмүүсийн тухай – хүний хөгжлийн үр дүнд тэдний сонголт хийх боломж хэрхэн өргөжин хөгжиж байгаа тухай өгүүлнэ. Сонголт хийнэ гэдэг нь ҮНБ-ний өсөлт, орлого, эд баялаг болон бараа таавар, өргөн хэрэглээний бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хөрөнгө хуримтлуулахаас илүү чухал зүйл юм. Хүний хөгжил нь хүмүүс сонголт хийх боломж бололцоог олгодог. Хэн ч хүний аз жаргал, баяр


баясгалангийн баталгааг өгч чадахгүй ба хүмүүсийн хувийн сонирхол нь тэдний хийх сонголтуудыг бий болгодог.

Гэвч хөгжлийн үйл явц нь дор хаяж хувь хүн болон хамт олонд хамаарах хүрээлэн байгаа орчинг бий болгох, хүмүүсийн чадавхи бүрэн дүүрэн ашиглах, хүмүүсийн сонирхол, хэрэгцээний дагуу үйлдвэрлэл явуулж бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломж олгодог. Хүний хөгжлийн индексээр тодорхойлбол – дундаж наслалт, бичиг үсгийн мэдлэг, амьдралын баталгаа зэрэг болно. Илтгэлд хотжилтын явцад хөгжлийн асуудал гарч байгаа бэрхшээлүүдэд анхарсаан байна.

Хүний хөгжлийн илтгэл 1991

Хүмүүсийн улс төрийн ухамсар төгс төлөвшөөгүй нь хүнийг ялгаварлан гадуурхан үзэх үзлийн үндэс болж байгаа тухай өгүүлвэл: Төсөвт зардлыг судалснаар хүний хөгжилд төрийн оролцоо ямар байгааг энэ график харуулж байна.

Энэ илтгэлийн гол дүгнэлт нь санхүүгийн нөөц болоцооноос үл шалтгаалан улс төрийн ухамсар дорой байх хүнийг ялгаварлан гадуурхах бодит шалтгаан болж ирсэн. Өнөөгийн байдлаар хөрөнгө мөнгийг тодорхой чиглэлгүй, үр дүн муутай зарцуулж байна. Хэрэв эдийн засгийн тэргүүлэх чиглэлийг зөв тодорхойлсон бол хүний хөгжлийн дэвшилд илүү их тус дөхөм болох байсан. хөгжил нь хүмүүсийн оролцоотойгоор урагшилдаг. Ийм учраас хүмүүс эрүүл мэнд, боловсролдоо өөрсдийн чадавхи боломжийн хэрээр хөрөнгө оруулна. Түүнчлэн тэд өөрсдийн амьдралын олон талт асуудалд бүрэн дүүрэн хамрагдах, санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх, хийж бүтээх боломжоо ашиглах ёстой.




Хүний хөгжлийн илтгэл 1992

Дэлхийн зах зээл ядуучуудын хэрэгцээг хэрхэн хангаж чадаж буюу чадахгүй байсныг үнэлвэл:

Дэлхийн эдийн засгийн тэнцвэртэй бус байдал

Дэлхийн нийт эдийн засгийн арга хэмжээний тархалтыг 1989 оны байдлаар хувиар харуулахад /хүн амын тоог орлогын байдлаар нь ангилав/




Энэ график нь дэлхийн ядуу улсуудын 20 хувьтай харьцуулбал дэлхийн баян улсуудын 20 хувь нь нийт баялгийг тэднээс 60 дахин илүү эзэмшиж байгааг харуулж байна.

Тус илтгэл нь дэлхийн зах зээл дэлхийн ядуучуудын эрэлт хэрэгцээг хэрхэн хангаж чадаж байгаа буюу чадахгүй байгаад дүн шинжилгээ хийсэн. Хөгжиж байгаа орнууд нь дэлхийн зах зээлд жил бүр 500 тэрбум ам.долларын эргэлттэй орж байхад тэдний авч байгаа гадаадын тусламж нь 10 дахин илүү байна. Сүүлийн 30 жилийн турш дэлхийн орлого нь 2 дахин өсөөнд гайхах явдалгүй. Хүннэ хөгжүүлж, шинэ техник, технологи нэвтрүүлснээр дэлхийн зах заалд өрсөлдөх боломж нээгддэг байна. Жишээ нь: Зүүн Азийн бар орнууд. Түүнчлэн дэлхий дахинаа шинэчлэлт өөрчлөлтийн суурь тавигдаж байна.

Хүний хөгжлийн илтгэл 1993

Хүмүүс хэрхэн өөрсдийн амьдралын үйл явцад оролцож байгааг харуулбал:



1975 оноос хойш ажил эрхлэлтийн өсөлт нь ҮДНБ-ээс байнга хол хоцорсон бөгөөд энэ хоорондын зай нь 1990-ээд оны үед улам тэлэх хандлагатай байна. Үүнийг "ажилгүйдлийн өсөлт" гэж нэрлэдэг.

Энэ илтгэлд хүмүүс өөрсдийн амьдралын үйл явцад хэрхэн яаж оролцож байгааг авч үзсэн юм.


Хүн төвтэй дэлхийд наад зах нь нийгмийн 5 гол хүч байна:

- Хүмүүсийн өдөр тутмын амьдралын аюулгүй байдал,
- Хүний тогтвортой хөгжлийг хангах,
- Төр болон зах зээлийн харилцаа холбоог байгуулах ба зах зээлийн үр дүнг нийгмийн хамгаалалтай холбох,
- Үндэсний болон дэлхийн үүрэг хариуцлагыг чиглүүлэх,
- Олон улсын хамтын ажиллагааны шинэ хэлбэрийг хүмүүсийн эрэлт хэрэгцээнд шууд хандуулах.

Түүнчлэн энэхүү илтгэл нь төвлөрлийг сааруулахад нэвтрэх нэг алхам болох шийдвэр гаргах үйл явцад оролцохыг авч үзсэн. Олон улсын болон үндэсний хэмжээний асуудалд төрийн бус байгууллагуудын үүрэг нөлөөг нэмэгдүүлэх талаар бичжээ.

Хүний хөгжлийн илтгэл 1994


Хүмүүс орон гэр, ажлын байр, хүрээлэн байгаа орчиндоо хэрхэн аюулгүй амьдарч байгаа талаар аюулгүй байдлын шинэ ойлголттой холбон үзвэл:



1987-94 онд дэлхийд цэргийн зардал буурсаар 935 тэрбум ам.долларын дивидент (ашиг) энх тайвны үйлст зориулах эх үүсвэр бий болов. 1995-2000 онд дэлхийн цэргийн зардал жилд 3 хувиар буурна гэж үзвэл 460 тэрбум ам.доллар энх тайвны зориулалтаар ашиглалтлах боломжтой юм.

Хүний хөгжлийн илтгэл 1995

Жендерийн (хүйсийн ялгаа) асуудлыг хүний хөгжлийн хүрээнд авч үзвэл:



Энэ график нь эдийн засагт эмэгтэйчүүдийн оруулж байгаа хувь нэмрийг дутуу үнэлдэг явдлыг харуулж байна:


- эмэгтэйчүүд ажлын илүү ачаалалтай байдаг,
- эрэгтэйчүүд зах зээлд ажилласан хөлснийхээ 3/4-ыг авдаг байхад эмэгтэйчүүд зөвхөн 1/3-ийг авдаг байна,

- эрэгтэйчүүд орлогын дийлэнхи хэсгийг олж ихэнхэ ажлыг хийж байгаа мэтээр ойлгогдож байхад эмэгтэйчүүд бага цалин авч, хөдөлмөр нь бага үнэлэгдэж, хийсэн ажил нь харагдахгүй хоцордог.

Илтгэл өнгөрсөн цөөн жилийн хугацаанд хүйсийн ялгааг(жeндeр) багасгах талаар хийсэн ажилд дүн шинжилгээ хийсэн. Түүнчлэн эмэгтэйчүүдийн чадавхийг өргөтгөх болон тэдгээрийн хүйсийн тэгш эрхийн талаарх асуудлын хооронд орхигдож байгаа бусад асуудлуудыг тодотгох, тухайлбал эмэгтэйчүүдийн ажил хөдөлмөрийг дутуу үнэлэх, ирээдүйд хүйсийн асуудлыг тэгшитгэх 5 заалт бүхий зорилт дэвшүүлэн тавив. Энэ илтгэлд нийлмэл 2 шинэ үзүүлэлтүүдийг тодорхойлсон байна. Үүнд: 1) хүйсийн хөгжлийн хамаарлын индекс, 2) хүйсийн бүрэн эрхийн хэмжээ гэсэн энэ 2 үзүүлэлтээр улс орныг хүйсийн тэгш эрхийн хувьд ямаршуухан байдалтай байгааг нь тодорхойлж өгч байна. Эхнийх нь буюу хүйсийн хөгжлийн индекс нь жендерийн (хүйсийн ялгаа) хүний чадавхи боломжоор, харин хоёр дахь үзүүлэлт нь хүйсийн ялгааг улс төр, эдийн засгийн амьдралд болон шийдвэр гаргах үйл явцад хэрхэн яаж оролцож, нөлөөлж байгаагаар нь тодорхойлдог.

Хүний хөгжлийн илтгэл 1996

Эдийн засгийн болон хүний хөгжлийн уялдаа холбоог харуулбал:



*ЭЗХАХБ-Эдийн засгийн хамтын ажиллагаа хөгжлийн байгууллага

Босоо шугамын баруун талд үзүүлсэн хсэг нь 1990-ээд онд урьд нь хэзээ ч тийм өндөр хэмжээний орлоготой байгаагүй орнуудыг харуулав. Зүүн гар талд нь 1990-ээд онд урьдхаасаа бага орлоготой байсан хүмүүсийг харуулав.

Эдийн засгийн өсөлт, хүний хөгжил хоёр нь үргэлж хамтдаа хөгжиж байдаг боловч энэ талаархи холбоо, энгийн баримт ч байдаггүй, цаг ямагт орхигддог. Илтгэл эдийн засгийн өсөлт ба хүний хөгжил хоёрын хоорондын холбооны тухай асуудлыг дэлхийн олон оронд авч үзэлгүй орхигдуулсныг тусгав. Эдийн засгийн өсөлт, хүнийн хөгжил нь нэг нь нөгөөгүйгээрээ тогтвортой байж чадахгүй гэдгийг энэ илтгэлд онцлон тэмдэглэсэн. Энэхүү илтгэлд хэрвээ эдийн засгийн өсөлтийг зөв удирдахгүй

бол ажилгүйдэл, хэргийлэл, суурьгүй, ирээдүйгүй байдал үүсч улмаар эдгээр нь хүний хөгжил ба тогтвортой байдалд хохирол учруулж болох юм гэсэн санааг тусгасан. Мөн эдийн засгийн өсөлт ба хүний хөгжил хоёрын хоорондын холбоо нь чадварлаг болон ухаалаг удирдлагын бодлогын үр дүнд тогтмол батжиж байх талаарх дүгнэлтийг бичсэн. Ажил эрхлэлт нь эдийн засгийн өсөлтийн ашиг орлогыг хүний амьдралд нэвтрүүлэхэд шийдвэрлэх үүрэгтэй гэдгийг нотлов. Энэхүү тохиолдолд 21-р зуунд өсөлтийн шинэ хэв загварууд үүсч, тогтворжих хэрэгтэй бөгөөд сул болон эмзэг өсөлтийг нэгтгэснээр дэлхийн эдийн засгийг өргөтгөжүүлэх шинэ механизм хөгжих учиртай.

3. Монгол хүний хөгжлийн илтгэл 1997

Хүний хөгжлийн үндэсний илтгэл гэдэг нь хүний хөгжлийн явцад илрэн тодорч байгаа тухайн улс орны эдийн засаг, нийгмийн түвэгтэй асуудлуудтай уялдаа холбоо бүхий судалгаа, дүн шинжилгээгээр нотлогдсон баримт бичиг юм.

Монгол хүний хөгжлийн илтгэлийн гурван гол зорилт:

Зорилт	Үр дүн
Доорхи дурьдсан 3 асуудлаар Монгол хүний хөгжилд дүн шинжилгээ хийх чадавхийг тодорхойлно: - хүний хөгжлийн тухай үндсэн ойлголт, - уялдаа холбоо бүхий аргууд болон үзүүлэлтүүд, - олон улсын тодорхойлолт	- статистикийн тоо баримт, мэдээллийг өргөнөөр ашиглах, - статистикийн тогтолцооны сул талыг тогтоох, - яамд хоорондын мэдээллийн солилцоог нэмэгдүүлэх, - засгийн газар болон ард түмний хоорондын мэдээллийг шуурхай болгох
Монгол хүний хөгжлийн хөтөлбөр, стратегийг - засгийн газрын бодлого боловсруулагчид, - төрийн бус байгууллагууд, - судалгааны төвүүд, - тусламжийн агентлагуудыг оролцуулан томъёолох.	- хүний хөгжлийн хувьсал, статусын албан ёсны мэдээ, тайланг гаргах, - ололт, амжилт, дутагдалтай талыг тогтоох, - хэлэлцэх асуудлыг оновчтой сонгох, - үйл ажиллагааны тэргүүлэх үүргийг тогтоох, - бодлогын удирдамжаар хангах
Монгол дахь хүний хөгжлийн асуудлаарх сурталчилгаа, мэдлэгийн эх үүсвэр нь: - хөгжлийн стратеги, зорилтын талаарх үндэсний мэдээллийг дэмжин урамшуулах, - удирдагчид, бодлого боловсруулагчид, судлаачид зэрэг нөлөө бүхий хүмүүсийн санал бодлыг харгалзах, - илтгэлийн талаар мэдээ мэдээлэл.	- хүний хөгжлийн үйл ажиллагааг дэмжих, дэмжлэг тусалцааг дайчлах, - хүний хөгжлийн тулгамдсан асуудлаар үндэсний хэлэлцүүлэг, маргааныг санаачлан дэмжих, - засгийн газрын бодлоготой уялдуулах, - гадаадын тусламж, олон улсын мэдээллийг нэмэгдүүлэх